БАЯНХОНГОР АЙМАГТ 2019 ОНЫ 01 ДҮГЭЭР САРД
БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2019 оны 02 дугаар сарын 04 Баянхонгор сум

1. **Тухайн сард нийт 329 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгав. Үүнээс:**

Гэмт хэргийн шинжтэй — **125 буюу 37,9%**

- ✓ 113 буюу 90,4 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн
- ✓ 12 буюу 9,6 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гаргасан.

Зөрчлийн шинжтэй — **204 буюу 62,1%**

- ✓ 127 буюу 62,2 хувийг Зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдсэн
- ✓ 76 буюу 37,2 хувийг зөрчлийн шинжгүй үндэслэлээр татгалзсан
- ✓ 1 буюу 0.4 Харъяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлэсэн байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 66,8%-ийг 5 хоногт, 4,5%-ийг 6 ба түүнээс дээш хоногт, Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 185 буюу 90.6%-ийг 3 хоногт, 41 буюу 9.3%-ийг 4 ба түүнээс дээш хоногт тус тус шалгаж шийдвэрлэсэн.

2. **Бүртгэгдсэн гэмт хэрэг:**

2019 оны 01 дүгээр сард орон нутгийн хэмжээнд **1214** гэмт хэрэг бүртгэгдсэний **124** буюу **10,2**%-ийг Баянхонгор аймагт бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үедтэй харьцуулахад 63 нэгжээр буюу 1,3 дахин өссөн байна.

	2018 оны 01 сар	2019 оны 01 сар	Өсөлт, бууралт	
			тоогоор	Хувиар
Бүртгэгдсэн нийт хэрэг	4019	3827	-192	-4,7%
Орон нутагт бүртгэгдсэн гэмт хэрэг	1048	1214	166	16%
Баянхонгор аймаг гэмт хэрэг	**61**	**124**	**63**	**1,3 дахин**

Бүртгэгдсэн хэргийн илрүүлэлт:
/хувиар/

	2018 оны 01 сар	2019 оны 01 сар	Өсөлт, бууралт /нэгжээр/
Улсын хэмжээнд	6,1%	8,0%	1,9 пунктээр өссөн
Орон нутагт	0,1%	0,1%	Ижил түвшинд
Баянхонгор аймагт	**4,4%**	**6,9%**	**2,5 пунктээр өссөн**



Баянхонгор сумын багуудад гарсан гэмт хэрэг

Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал



2019 оны 01 дүгээр сарын байдлаар

Хэргийн ангилал	2018 оны 01 сар	2019 оны 01 сар	Харьцуулалт	
Хүнийг санаатай алах	0	**1**	1	100%
Золгүй учрал	3	**5**	2	67%
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	30	**26**	-4	-13.3%
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	0	**55**	55	100%
Өмчийн хулгай	23	**33**	10	43.4%
Тээврийн хэрэгслийн хулгай	1	**0**	-1	-100.0%
Мал хулгайлах	7	**13**	6	85.7%
Дээрэм	0	**0**	-	-
Залилах	5	**5**	-	-
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	0	**0**	-	-

ХАБЭГХ	2	**1**	-1	-50%
Бусад	5	**61**	56	11 дахин

Урьд оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлтийг хувиар илэрхийлэн үзвэл: Хүнийг санаатай алах 100%-иар, Золгүй учрал 67%-иар, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 100%-иар, Өмчийн хулгай 43,4%-иар, Мал хулгайлах гэмт хэрэг 85,7%-иар өсөж,

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг -13,3%-иар, Тээврийн хэрэгслийн хулгай -100%-иар, Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг -50%-иар тус тус буурсан.

Дээрэмдэх, Залилах, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргүүдэд өсөлт бууралт байхгүй, ижил түвшинд байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал

Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал	2018 оны 01 сар	2019 оны 01 сар	Нэгжээр	Өсөлт бууралт /хувиар/
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	5	3	-2	-40%
Эмэгтэй хүн оролцсон	2	7	5	2,5 дахин
Хүүхэд оролцсон	-	-	-	-
Бүлэглэн гүйцэтгэсэн	11	9	-2	-18,1%
Согтуугаар	10	4	-6	-60%

Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн газар

Баянхонгор аймагт бүртгэгдсэн 124 гэмт хэргийн 51 буюу 58,8% нь гэр оронд, 13 буюу 10,4% нь гудамж талбайд, 9 буюу 7,2% нь олон нийтийн газар, 4 буюу 3,2% нь бусад газар, 2 буюу 1,6% нь аж ахуйн нэгж, 19 буюу 15,3% нь төрийн байгууллагад үйлдэгдсэн байна.

Үйлдэгдсэн гараг:



Үйлдэгдсэн цаг:



3. Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Энэ хугацаанд нийт 12 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 нэгжээр буюу -33,3 хувиар буурсан бөгөөд 1 эмэгтэй, 11 эрэгтэй холбогдон шалгагдсан байна.

3.1. Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:

Гэмт хэргийн улмаас 113 иргэн хохирч, үүнээс 18 хүн гэмтэж, 6 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал гэмтсэн хүн 8 нэгжээр буюу -30,7%-иар буурч, нас барсан хүн ижил түвшинд байна.

Гэмт хэргийн улмаас 123.5 сая төгрөгийн хохирол учирснаас 15.7 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт өнгөрсөн оны мөн үеэс 12,7%-иар өссөн.

4. Зөрчлийн мэдээ

Баянхонгор аймгийн хэмжээнд 2019 оны 1 дүгээр сарын байдлаар 1911 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 814 нэгжээр буюу 74.2% өссөн үзүүлэлттэй байна. Дээрх илэрсэн зөрчлийг хамгийн их ердийн журмаар буюу бэлэн бус торгуулийн арга хэмжээгээр 1775 зөрчлийг 28820.0 мянган төгрөгөөр, 136 зөрчлийг хялбаршуулан шалгах



журмаар шийдвэрлэж 23720.0 мянган төгрөгөөр, нийт 1911 зөрчлийг 52540.0 мянган төгрөгөөр торгосон.

-13 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4 нэгжээр буюу 23,5%-иар буурсан.

-32 зөрчлийг торгож, эрх хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19 нэгжээр буюу 37.2 %-иар буурсан үзүүлэлттэй байна.

Зөрчил үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилтэй харьцуулсан эзлэх хувь

Зөрчил гарсан цагаар нь:		**Зөрчил гарсан өдрөөр нь:**	
06-12 цагт	337 буюу 17.6%	Даваа гараг	325 буюу 17%
		Мягмар гараг	300 буюу 15.6%
13-18 цагт	959 буюу 50.1%	Лхагва гараг	312 буюу 16.3%
		Пүрэв гараг	316 буюу 16.5%
19-24 цагт	567 буюу 29.6%	Баасан гараг	292 буюу 15.2%
		Бямба гараг	185 буюу 9.7%
01-05 цагт	48 буюу 2.5%	Ням гараг	181 буюу 9.5%

Энэ хугацаанд 95 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеинйхтэй харьцуулахад 3 нэгжээр буюу 3.2%-иар өссөн үзүүлэлттэй байна. Эрүүлжүүлэгдсэн хүний 8 буюу 8.4% нь эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхтой харьцуулахад 6 нэгжээр буюу 3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Саатуулагдсан шалтгаанаар нь авч үзвэл:

- Бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан 93 буюу 97.8%
- Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож гэмт хэрэгт болон хэрэг зөрчилд холбогдсон 2 буюу 2.2%

Саатуулагдсан газраар нь:

- Гэр, орон сууцнаас 61 буюу 64.2%
- Гудамж талбайгаас 15 буюу 15.7%
- Байгууллага, аж ахуйн нэгжээс 2 буюу 2.1%
- Баар, цэнгээний газраас 10 буюу 10.5%
- Зочид буудлаас 3 буюу 3.1%
- Үзвэр үйлчилгээний газар 3 буюу 3.1%
- Бусад газар 1 буюу 1% нь саатуулагдсан.

Энэ оны байдлаар архины эмчилгээнд сайн дурааараа 6 хүн хамрагдсан байна.

ДҮГНЭЛТ

Баянхонгор аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад огцом өсөлттэй буюу 63 нэгжээр нэмэгдэж 124 хэрэг бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтээс харахад Хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, орон байрны хулгайлах гэмт хэргийн гаралт нэмэгдсэн нь өсөлтөд нөлөөлөх гол шалтгаан гэж тодорхойлж болохоор байна. Энэ 2 төрлийн гэмт хэрэг тоон мэдээнд нөлөөлөх болсон шалтгааныг судлахад:

- Аймгийн Прокурорын газартай хамтран Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн шинжтэй мэдээллийг хамтран шалгаж, хуульд заасан хэрэг шалгах хугацааны дагуу шалгаж шийдвэрлэсэн нь тоо нэмэгдэх хүчин зүйл болсон.
- Цагдаагийн байгууллагаас орон даяар зохион явуулсан “Сар шинэ-2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн цагдаагийн газарт бүртгэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр хэсэгчилсэн арга хэмжээг аймагтаа зохион явуулсны үр дүнд эзэнгүй байсан 26 гэмт хэргийг одоогийн байдлаар үйлдсэн этгээдүүдийг олж тогтоон шалгалтын ажлыг хийж байгаа бөгөөд цаашид хохирогч нь тогтоогдоогүй хулгайн эд зүйлийг хураан авч ажиллагааг үргэлжүүлэн хийж байна.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдсэн, Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэрэг ихэвчлэн ахуйн хүрээнд хүч хэрэглэх эсвэл хүч хэрэглэхээр заналхийлж үйлдэгдэж байгаа нь уг хэрэг гомдол гаргахаас илүүтэйгээр далд хэлбэрт байдаг учир хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж байгаатай холбоотой гэж дүгнэхээр байна.

САНАЛ

1. Гэмт хэрэг өсөхөд нөлөөлсөн Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг хөдөө сумдыг хамруулан зохион байгуулж, цагдаагийн байгууллага иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах, тухайн гэмт хэргийн талаарх мэдээллийг иргэдээс төлбөртэй авах журмын хэрэгжилтийг хангах,
2. Хөдөө сумдын иргэдтэй уулзалт хийх үед гаргасан санал санаачлага, хүсэлтийг хүлээн авч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, үйл ажиллагаандаа ашиглах боломжийг судлах, хэрхэн хамтран ажиллах талаар ойлголцох, мэдээлэл олгох,
3. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр шинийг эрэлхийлсэн нийтийг хамарсан арга хэмжээг эхлүүлэх, Малчдын бүлгэмийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, урамшуулах тогтолцоог сэргээх, идэвхжүүлэх,

ТАНИЛЦУУЛГА ГАРГАСАН:
ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ХҮҮХДИЙН ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ЦАГДААГИЙН ХОШУУЧ Г.АНХБАЯР

ТАНИЛЦСАН:
ДЭД БӨГӨӨД ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ Н.ӨНӨМӨНХ